



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 05 сарын 25 өдөр

Дугаар 241

Улаанбаатар хот

Хөрөнгө, өр төлбөр бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.а дах заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Дэлхийн банкны зээлийн хөрөнгөөр санхүүжүүлсэн “Улаанбаатар хотын дулаан хангамжийн үр ашгийг нэмэгдүүлэх төсөл”-ийн хүрээнд бий болсон нийт 5,288,612,156.13 (таван тэрбум хоёр зуун наян найман сая зургаан зуун арван хоёр мянга нэг зуун тавин зургаан төгрөг арван гурван мөнгө) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгө, холбогдох өр төлбөрийг “Улаанбаатар дулааны сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Тавинбэх, “Улаанбаатар дулааны сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Г.Баярсайхан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө, өр төлбөрийг Сангийн яамтай тооцоо нийлэн хүлээлцэх, тооцоо нийлэх ажлыг компанийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132005353
14-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн
... дугаар тогтоолын хавсралт

"Улаанбаатар дулааны сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэх хөрөнгийн жагсаалт

Д/д	Объект, тоног төхөөрөмжийн нэр, байршил	Хүчин чадлын нэгж	Тоо хэмжээ	Гэрээний дүн /гүйцэтгэлээр/	Капиталжуулах дүн			Хөрөнгөд бүртгэх дүн (төгрөг)
					Зээлийн хүү	Хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны хураамж	ТХНэгжийн зардал	
1	3г магистраль, ТК-521-ээс ТК- 328 хүртэл 1ф600, 2ф400мм-голчтой дулааны шугамыг 2ф700мм болгож өргөтгөн шинэчлэх барилга угсралтын ажил" /W-3G-7/	Ф700мм	2ф720м м 869 хос метр, 2ф530м м 17 хос метр	4,627,746,482.37	378,808,938.21	30,857,496.88	185,109,859.29	5,222,522,776.76
2	3г магистраль, ТК-521-ээс ТК- 328 хүртэл 1ф600, 2ф400мм-голчтой дулааны шугамыг 2ф700мм болгож өргөтгөн шинэчлэх ажлын зураг төсвийн тодотгол, зохиогчийн хяналт, CS-3G-2			60,663,764.00	2,661,622.63	337,442.19	2,426,550.56	66,089,379.37
	НИЙТ ДҮН			4,688,410,246.37	381,470,560.84	31,194,939.07	187,536,409.85	5,288,612,156.13
				(дөрвөн тэрбум зургаан зуун жаран найман сая дөрвөн зуун арван мянга хоёр зуун дөчин зургаан төгрөг гучин долоон мөнгө)	(гурван зуун наян нэгэн сая дөрвөн зуун далан мянга таван зуун жаран төгрөг наян дөрвөн мөнгө)	(гучин нэгэн сая нэг зуун ерэн дөрвөн мянга есөн зуун гучин есөн төгрөг долоон мөнгө)	(нэг зуун наян долоон сая таван зуун гучин зургаан мянга дөрвөн зуун есөн төгрөг наян таван мөнгө)	(таван тэрбум хоёр зуун наян найман сая зургаан зуун арван хоёр мянга нэг зуун тавин зургаан төгрөг арван гураван мөнгө)